



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 01

Номгон

Г Санал хүргүүлэх тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянговь сумын Сум хөгжүүлэх сангаас Соёлын төвийн барилгын гүйцэтгэгч болох ЭЙ АР БИ СИ ХХК-д 10.0 сая төгрөгийн зээлийг, зээлийн хүүг Баянговь сумын Соёлын төв төлөхөөр гурвалсан гэрээ байгуулан олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.2-д "Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна," гэсэн заалтыг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.13-д "төрийн албан хаагч ...албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитын явцад илэрвэл түүнд хууль тогтоомжид заасны дагуу сахилгын хариуцлага тооцуулах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан "Төсвийн хөрөнгийг ...зориулалт бусаар зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн", 4.1.5-д заасан "... мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага нөхцлийг хангаагүй" гэсэн заалтуудыг үндэслэн

ШААРДАХ нь:

2517107

1. Баянговь сумын Засаг дарга Б.Эрдэнэбилэгт сахилгын шийтгэл ногдуулж, захирамжийн хувийг 2018 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэсэн заалтын дагуу шийдвэрлүүлэх болно.

АУДИТОР  БИЧСЭН: Ж.ӨСӨХБАЯР



6477 43544
БНДА0007 9007423

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:  БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛ





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 02.

Номгон

Г Санал хүргүүлэх тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Баянговь сумын Соёлын төвийн барилгын гүйцэтгэгч болох ЭЙ АР БИ СИ ХХК-д Сум хөгжүүлэх сангаас олгосон 10.0 сая төгрөгийн зээлийн хүүг Соёлын төв хариуцан төлөхөөр гурвалсан гэрээ байгуулсан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.13-д "төрийн албан хаагч ...албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитын явцад илэрвэл түүнд хууль тогтоомжид заасны дагуу сахилгын хариуцлага тооцуулах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан "... мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага нөхцлийг хангаагүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Баянговь сумын Соёлын төвийн эрхлэгч Г.Сугар-Эрдэнэд сахилгын шийтгэл ногдуулж, захирамжийн хувийг 2018 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэсэн заалтын дагуу шийдвэрлүүлэх болно.

АЛБАН ШААРДЛАГЫГ
БИЧСЭН:
АУДИТОР  Ж.ӨСӨХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:
БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА
 Б.ЭРДЭНЭБИЛЭГ

2517110



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 41

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянговь сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 33 иргэний 86826.8 мянган төгрөгийн зээлийн гэрээний хугацаа дуусч хугацаа хэтэрсэн байна.

2. Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого, зарлага, зээл авсан зээлдэгчдийн зээлийн үлдэгдлийн мэдээллийг журамд заасан хугацаанд аймгийн Засаг даргад хүргүүлээгүйгээс Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах нөхцлийг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 3.5.5-д " зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх", 5.4-д " Сумын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг... аймгийн Засаг даргад хүргүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2-д "Өмч, хөрөнгийг зохих шийдвэргүйгээр бусдад зүй бусаар ашиглуулсан,...", 4.1.5-д заасан "... мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага нөхцлийг хангаагүй", 4.1.7-д "Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

2518042

3. Хугацаа хэтэрсэн зээлүүдийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, санд төвлөрүүлэх.

4. Сангаас олгосон зээлүүдийн үлдэгдэл болон орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлж зээлдэгчдийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах нөхцлийн бүрдүүлэх.

5. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянговь сумын Засаг дарга Б.Эрдэнэбилэг, Санхүүгийн албан дарга Б.Энх-Амгалан, Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтэн Э.Гантулга нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

<p>АУДИТОР  БИЧСЭН:</p> <p>Ж.ӨСӨХБАЯР</p>	<p>ЗӨВШӨӨРСӨН:</p> <p>БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА  Б.ЭРДЭНЭБИЛЭГ</p> <p>САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА:  Б.ЭНХ-АМГАЛАН</p> <p>МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСГИЙН МЭРГЭЖИЛТЭН:  Э.ГАНТУЛГА</p>
---	--

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 48

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр их засвар, техник зохион байгуулалтын ажлын төлөвлөгөөг батлуулахдаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний төсвийг зардлын зүйл ангиар задлаагүй, бөөн дүнгээр баталсан, тайлант онд батлагдсан 3 арга хэмжээний төсвийг 10,1 сая төгрөгөөр хэтрүүлсэн, бараа материалыг бэлтгэхдээ сонгон шалгаруулалт зарлаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “төрийн болон орон нутгийн өмчийн этгээд .. захиалагч байна”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна ...” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн ТУЗ-өөр баталсан их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний бараа материалын худалдан авалтыг Төрийн өмчийн болон орон

2518055

нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах, батлагдсан төсөвт багтаан ажлыг гүйцэтгэх

2. Албан шаардлагын биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт 2018 оны 10 дугаар сарын 20-ны дотор ирүүлэхийг “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Отгонбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Батбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА

АУДИТОР

Ж.ӨСӨХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Т.ОТГОНБААТАР

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТБААТАР

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.